# "МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| | |
|---|---|
| *Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/* | |
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| *Тайлагнах хугацаа* | 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: "Монгол шуудан" ХК<br>УБГД: 9012001026<br>ҮЦК: MNP, MN00MNP05412<br>Утас: 976 70078918, 976 11330788 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүргүүлсэн огноо* | "Ниямазон Аудит" ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 99,586,363 (ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав) ширхэг |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Бэлтгэсэн:<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ<br><br>Хянасан:<br>Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн<br>Дэд захирал Н.Хосбаяр |

*1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

| | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2023.01.01) | Эцсийн үлдэгдэл (2023.12.31) |
|---|---|---|---|
| *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | **ХӨРӨНГӨ** | | |
| | Эргэлтийн хөрөнгө | 32,998,035,614.88 | 27,571,962,930.20 |
| | Эргэлтийн бус хөрөнгө | 10,513,377,114.82 | 10,805,095,264.30 |
| | **Нийт хөрөнгө** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.50** |
| | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| | Өр төлбөрийн нийт дүн | 18,519,802,578.46 | 12,229,681,716.05 |
| | Эздийн өмч | 24,991,610,151.24 | 26,147,376,478.45 |
| | **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.50** |
| *Орлогын тайлан* | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2023.01.01) | Эцсийн үлдэгдэл (2023.12.31) |
| | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **18,491,088,870.70** | **19,369,578,379.77** |
| | Борлуулалтын өртөг | 18,464,332,021.74 | 21,526,001,245.47 |
| | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 699,324,104.27 | 598,858,309.48 |
| | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 1,317,824,602.97 | 1,763,883,195.83 |
| | Бусад | 1,201,078,732.14 | 5,393,800,778.03 |
| | **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **609,335,082.40** | **2,107,851,485.36** |
| | **Орлогын татварын зардал** | 158,051,990.96 | 140,136,455.05 |
| | **Татварын дараах ашиг** | **451,283,091.44** | **1,967,715,030.31** |
| *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2023.01.01) | Эцсийн үлдэгдэл (2023.12.31) |
| | **Эздийн өмч** | **9,958,636,300.00** | **9,958,636,300.00** |
| | **Хуримтлагдсан ашиг** | **4,814,083,519.71** | **6,556,222,661.62** |

| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл (2023.01.01) | Эцсийн үлдэгдэл (2023.12.31) |
|---|---|---|---|---|
| | | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,434,889,424.77** | **-2,505,920,850.98** |
| | | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **-1,420,066,566.21** | **-1,517,624,299.33** |
| | | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **-192,939,819.90** | **-221,219,675.23** |
| | | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **5,081,969,604.74** | **-3,237,431,731.03** |

*1.1* *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт*

Үндэсний аудитын газраас өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

1.2 Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2024.03.15 № 07/1443

танай ____ -ны № ____ -т

МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АНХБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол шуудан ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол шуудан ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал дахь 5,358.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Илгээмж боловсруулах төв"-ийг 2020 онд эхлүүлж, барилгын ажлыг 2024 оны 1 дүгээр сард ашиглалтад оруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол шуудан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22/15 дугаар тогтоолоор компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж, нийт орлогыг 22,884.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 22,175.9 сая төгрөгөөр, 708.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үндсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,518.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 25,397.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 23,289.9 сая төгрөгийг зарцуулж, 2,107.8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн чиглэлийн 9 зорилтын хүрээнд 176 арга хэмжээний ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсан аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

0001351364

*2.* *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл*

| | | |
|---|---|---|
| *2.1* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | 2023 онд 637.3 сая.төг-ийн төлөвлөгөөтэй ажилласнаас гүйцэтгэлээр 1,967.9 сая.төг-ийн цэвэр ашигтай буюу 1,330.6 сая.төг-өөр давуулсан. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) үзүүлэлтийг тайлант хугацаанд 0.05, нэгж хувьцаанд ноогдох ашиг (EPS) үзүүлэлт тайлант хугацаанд 19.7 төг болж өссөн. |
| *2.2* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | 2023.12.31 байдлаар компанийн нийт хөрөнгийн дүн ₮38,601,261,699.57 ба үүнээс эргэлтийн хөрөнгө ₮27,796,166,435.27, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө ₮16,148,550,148.05 бол эргэлтийн бус хөрөнгө ₮10,805,095,264.30, түүний дотор үндсэн хөрөнгө ₮8,495,852,792.93 байна. |

| | | |
|---|---|---|
| *2.3* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл* | Компани үндсэн үйлчилгээний хүрээнд гадаад болон дотоод шуудангийн үйлчилгээг үзүүлдэг. Гадаад шуудангийн үйл ажиллагаанд 2 үндсэн хүчин зүйл бизнест сөргөөр нөлөөлж байна. 1. БНХАУ нь Монгол улсын гадаад худалдааны хамгийн том түнш. Тэр дундаа өргөн хэрэглээний зүйлсийн гол импортлогч орон. Гэтэл хил дамнасан цахим худалдааны илгээмж карго нэрээр хилээр ямар ч хяналтгүй, гаалийн татваргүй албан бусаар нэвтэрч, далд эдийн засгийг үүсгэж байгаа нь тэгш бус өрсөлдөөн, тэгш бус бизнесийн орчныг үүсгэж байна. 2. ОХУ нь Монгол улсын хөрш орон төдийгүй, шуудангийн өндөр солилцоотой улс. Орос-Украйны дайны нөлөөгөөр ОХУ-д тавигдсан хоригууд нь төлбөр тооцоо, шуудан солилцоонд сөргөөр нөлөөлж байна.<br>Дотоод шуудангийн зах зээлд өрсөлдөөн нэмэгдэж байна. Шуудангийн зах зээлийн 70 орчим хувь нь Улаанбаатарт, 30 орчим хувь нь орон нутгийн зах зээл эзэлж байна. Нөгөө талаад дотоод шуудангийн зах зээлд олон өрсөлдөгчид бий болсон боловч тус компаниас бусад нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг бол хамгийн өндөр зардалтай орон нутгийн зах зээлд тус компани дангаар үйлчилгээгээ үзүүлж байна. Гэвч компанийг дотоод шуудангийн зах зээлд монопол байдалтай ААН гэж үздэг тул үнэ тарифын бодлогыг зах зээлийн зарчмаар өсгөх нь хязгаарлагдмал тул дотоод шуудангийн бизнест орон нутгийн шуудан хүргэлтийн үйлчилгээ нь хамгийн их алдагдал хүлээдэг хэсэг болж байна.<br>Компани дээрх байдалд хариу арга хэмжээ авч үнэ тарифыг үе шаттай нэмэгдүүлэх, техник технологийн хөрөнгө оруулалт хийж бүтээмжээ нэмэгдүүлэх, олон улсын бизнесийг олон улсын нөхцөл байдалд уялдуулан хоёр талт хамтын ажиллагаагаар хөгжүүлэх бодлогуудыг хэрэгжүүлж байна. |
| *2.4* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* | Байхгүй |
| *2.5* | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл* | Байхгүй |
| *3.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй. | |
| *4.* | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд цалин болон бусад зардалд 172.сая төгрөг зарцуулсан байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн ХЭ-23/02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн сарын цалинг доорх дүнгээр баталсан.<br>ТУЗ-ийн дарга-1,500,000<br>ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга-1,400,000<br>ТУЗ-ийн бусад гишүүд- 1,300,000 | |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | **Засаглалийн бүтэц, үйл ажиллагаа**<br><br><u>Хувьцаа эзэмшигчдийн хурал</u><br><br>Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10:00 цагт компанийн 4 давхрын "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн хурлын танхимд зохион байгуулагдав. Хурлаас гарсан шийдвэрүүд:<br>1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлав.<br>2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлав.<br>3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлав. | |

Төлөөлөн удирдах зөвлөл

"Монгол шуудан" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон төлөөлөн удирдах зөвлөл удирддаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнийтэй бөгөөд 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнтэй. Тайлант хугацаанд гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй. ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдийн оролцоог жагсаалтаар орууллаа. Үүнд:

1. Даваахүү НАРАНГЭРЭЛ
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга

2. Даваасамба ДЭЛГЭРМАА
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга

3. Даваадорж БАЛЖИННЯМ
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

4. Батаа БАТЦЭЦЭГ
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

5. Одончимэд ОДБАЯР
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны дарга

6. Гэрэлт ТЭЛМЭН
   Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүн

7. Банзрагч ГАНБААТАР
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

8. Дарамбазар БАЛДОРЖ
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

9. Чүлтэм АМАРБААТАР
   Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

Удирдлагын баг

1. Бадамрай АНХБААТАР - Гүйцэтгэх захирал
2. Нанзад ХОСБАЯР - Олон улсын бизнес хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал
3. Даваахүү БАТТУЛГА - Бизнэс төлөвлөлт, хөгжлийн болон Шуудан, логистикийн газрын дарга
4. Баттулга СОДЧИМЭГ – Улс хоорондын шуудангийн газрын дарга
5. Баатархүү НАРАНЦЭЦЭГ – Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
6. Бат-Эрдэнэ ЦЭНД-АЮУШ – Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
7. Баярсайхан САЙНБАЯР – Мэдээллийн технологийн газрын дарга
8. Ганболд ГАНЧИМЭГ – Дотоод аудитын хэлтсийн дарга
9. Баярсайхан ДАМДИНБАЗАР – Марк, үнэт цаасны хэлтсийн дарга

<u>Компанийн бүтэц</u>

*"Монгол шуудан" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 06 сарын 21 өдрийн 92/14 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралт*

"МОНГОЛ ШУУДАН" ХК-ИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




## 6. *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

Шуудангийн бизнест дараах эрсдэлүүд нийтлэг үүсэж байгаа.

1. Ажиллах хүчний хомсдол. Шуудан хүргэлтийн үйл ажиллагаа нь хүний хөдөлмөрт суурилсан бизнес. Ажиллах хүчний хэрэгцээ шаардлага их байдаг тул зах зээлд гарч буй ажиллах хүчний хомсдол нь бизнесийн үйл ажиллагаанд эрсдэл дагуулж байна.
2. Инфляц, зардлын өсөлт. Шуудан тээвэр хүргэлтийн үйлчилгээнд ажиллах хүчний зардлын өсөлт, тээвэр шатахууны зардал, бусад зардлын өсөлт, инфляц бизнесийн тогтвортой үйл ажиллагаа, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.
3. Замын түгжрэл, бүтээмж. Шуудан тээвэр, хүргэлтийн үйл ажиллагаанд замын түгжрэл сөргөөр нөлөөлж байна. Тээвэр хүргэлт удаашрах, бүтээмж буурах, зардал өсөх шалтгаан болж байгаа тул гол эрсдэлийн нэг болж байна.

## 7. *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэр эзэмшлийн хувь нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржийн I ангилалд багтсан амжилтаа бататгаж, хувьцаа эзэмшигчдийн тоо 3,381-д хүрч 2023 оны туршид 1.2 тэрбум төгрөгийн 1.4 сая ширхэг хувьцаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдлаа.

| | |
|---|---|
| | <br> |
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээ* |
| | Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно. |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | 2022 оны ногдол ашгийг 2023 оны 12 дугаар сарын 18-ний өдөр "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% олгосон.<br><br>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 24/01 дугаар тогтоолоор компанийн 2023 оны цэвэр ашгаас 30.36 хувь буюу нэгж хувьцаанд 6.0 (зургаа) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтов. |
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | Олон улсын 52 дах удаагийн захидлын уралдааныг зохион байгуулахад хамтран оролцож, үндсэн сүлжээ эзэмшигчдийн хувьд 21 аймаг, 330 сумаас оролцуулан дэмжин ажиллалаа.<br><br>Дэвшилтэт Социал Демократ клуб ТББ, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Боловсролын үндэсний газартай хамтран хүслийн захидал аяныг Монгол орон даяар зохион байгуулж, улсын хэмжээний сургуулийн сурагчдын хүслийг сонсох аянд дэмжиж оролцсон.<br><br>Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх чиглэлээр "Хурдан" үйлчилгээг Улаанбаатар хот болон орон нутгийн салбар цэгүүдээр дамжуулан хүргэсэн. |

*Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:*

| | |
|---|---|
| *Овог, нэр:* Г.Тэлмэн<br>*Албан тушаал:* "Монгол шуудан" ХК-ийн гүйцэтгэх захирал<br>*Гарын үсэг:* ..............................<br>*(Тамга, тэмдэг)*<br>МОНГОЛ ШУУДАН<br>УЛААНБААТАР ХОТ | *Овог, нэр:* Б.Наранцэцэг<br>*Албан тушаал:* "Монгол шуудан" ХК-ийн Санхүүгийн газрын дарга<br>*Гарын үсэг:* ..............................<br>*(Тамга, тэмдэг)* |

*Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:*

*Овог, нэр:* Д.Цэцгээ

*Албан тушаал:* ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

*Гарын үсэг:* ..............................

*Огноо:* 2024.04.30

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12 дугаар сарын 31 | 2023 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 19,385,981,879.08 | 16,148,550,148.05 |
| 1.1.2 | Дансны авлага | 5,886,568,927.89 | 2,667,175,998.76 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 41,101,472.25 | 135,689,028.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 332,984,445.92 | 143,565,228.09 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 157,769,001.00 | - |
| 1.1.6 | Бараа материал | 3,479,935,861.85 | 3,498,586,855.77 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3,713,694,026.89 | 4,978,395,671.53 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **32,998,035,614.88** | **27,571,962,930.20** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 8,471,048,949.22 | 8,495,852,792.93 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,041,828,165.60 | 2,308,742,471.37 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 500,000.00 | 500,000.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **10,513,377,114.82** | **10,805,095,264.30** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.50** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 17,778,450,709.99 | 10,459,357,649.33 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | 230,582,579.90 |
| 2.1.1.3 | Татварын өр | 168,138,133.12 | 134,928,454.27 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | - | 14,161,569.68 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 339,069,766.99 | 917,222,935.68 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 234,143,968.36 | 473,428,527.19 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **18,519,802,578.46** | **12,229,681,716.05** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **18,519,802,578.46** | **12,229,681,716.05** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 6,572,700,000.00 | 6,572,700,000.00 |
| 2.3.2 | -хувийн | 3,385,936,300.00 | 3,385,936,300.00 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 2,538,512,210.45 | 2,538,512,210.45 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,379,919,523.85 | 3,379,919,523.85 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 4,300,458,597.23 | 3,714,085,782.53 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 4,814,083,519.71 | 6,556,222,661.62 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **24,991,610,151.24** | **26,147,376,478.45** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.50** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12 дугаар сарын 31 | 2023 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **18,491,088,870.70** | **19,369,578,379.77** |
| 2 | Борлуулалтын өртөг | 18,464,332,021.74 | 21,526,001,245.47 |
| **3** | **Нийт ашиг( алдагдал)** | **26,756,848.96** | **(2,156,422,865.70)** |
| 4 | Түрээсийн орлого | 115,241,194.05 | 137,959,815.10 |
| 5 | Хүүгийн орлого | 584,082,910.22 | 460,898,494.38 |
| 6 | Бусад орлого | - | - |
| 7 | Борлуулалт, маркетингийн зардал | - | - |
| 8 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,147,771,767.30 | 1,525,406,320.67 |
| 9 | Санхүүгийн зардал | - | - |
| 10 | Бусад зардал | 170,052,835.67 | 238,476,875.16 |
| 11 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 1,201,078,732.14 | 5,393,800,778.03 |
| 12 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | 35,498,459.38 |
| 13 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **609,335,082.40** | **2,107,851,485.36** |
| 14 | Орлогын татварын зардал | 158,051,990.96 | 140,136,455.05 |
| 15 | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **451,283,091.44** | **1,967,715,030.31** |
| 16 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | 451,283,091.44 | 1,967,715,030.31 |
| 17 | **Орлогын нийт дүн** | | |
| 18 | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдалтай)** | 451,283,091.44 | 1,967,715,030.31 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГ
01
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **6,572,700,000.00** | | **3,379,919,523.85** | **4,300,458,597.23** | **4,602,511,381.17** | **18,855,589,502.25** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 451,283,091.44 | 451,283,091.44 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 3,385,936,300.00 | 2,538,512,210.45 | | | (239,710,952.90) | 5,684,737,557.55 |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **9,958,636,300.00** | **2,538,512,210.45** | **3,379,919,523.85** | **4,300,458,597.23** | **4,814,083,519.71** | **24,991,610,151.24** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 1,967,715,030.31 | 1,967,715,030.31 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | (586,372,814.70) | | (586,372,814.70) |
| Зарласан ногдол ашиг | | | | | (225,575,888.40) | (225,575,888.40) |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **9,958,636,300.00** | **2,538,512,210.45** | **3,379,919,523.85** | **3,714,085,782.53** | **6,556,222,661.62** | **26,147,376,478.45** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12 дугаар сарын 31 | 2023 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 125,884,989,790.76 | 103,925,063,975.29 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 14,849,382,704.84 | 15,540,296,005.08 |
| | Бусад мөнгөн орлого | 111,052,607,085.92 | 88,384,767,970.21 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 121,450,100,365.99 | 106,430,984,826.27 |
| | Ажиллагчдад төлсөн | 7,244,776,405.17 | 8,075,806,596.46 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,266,214,006.36 | 2,483,989,133.86 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,949,629,551.54 | 2,278,190,902.30 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 1,819,030,861.01 | 1,882,203,696,27 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 3,240,415,086.86 | 3,605,436,850.60 |
| | Татварын байгууллагад төлсөн | 1,334,722,721.46 | 1,511,026,301.00 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 116,694,757.20 | 122,993,711.52 |
| | Бусад мөнгөн зарлага | 102,478,616,976.39 | 86,471,337,634.26 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,434,889,424.77** | **(2,505,920,850.98)** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 357,082,910.22 | 650,725,627.87 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 357,082,910.22 | 650,725,627.87 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,777,149,476.43 | 2,168,349,927.20 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,343,924,826.43 | 2,079,908,727.20 |
| | Биет бус хөрөнгө хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 283,224,650.00 | 88,441,200.00 |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 150,000,000.00 | - |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,420,066,566.21)** | **(1,517,624,299.33)** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 192,939,819.90 | 221,219,675.23 |
| | Төлсөн ногдол ашиг | 192,939,819.90 | 221,219,675.23 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(192,939,819.90)** | **(221,219,675.23)** |
| | **Валютын ханшийн зөрүү** | **2,243,086,566.08** | **1,007,333,094.51** |
| 4 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **5,081,969,604.74** | **(3,237,431,731.03)** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 14,304,012,274.34 | 19,385,981,879.08 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 19,385,981,879.08 | 16,148,550,148.05 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛ
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛ

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2023 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон* *Ісая.төгрөгөөр/*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| | | | 1 | 2 | 3 | 4=2-3 | 5 |
| 1. | Нийт орлого | сая.төг | 20,391.5 | 22,884.0 | 25,397.7 | (2,513.7) | 111.0 |
| 2. | Нийт зардал | сая.төг | 19,782.2 | 22,175.9 | 23,289.9 | (1,114.0) | 105.0 |
| 3. | Татварын өмнөх ашиг | сая.төг | 609.3 | 708.1 | 2,107.8 | (1,399.9) | 297.7 |
| 4. | Орлогын татварын зардал | сая.төг | 158.1 | 70.8 | 140.1 | (69.3) | 197.9 |
| 5. | Цэвэр ашиг | сая.төг | 451.3 | 637.3 | 1,967.8 | (1,330.5) | 308.8 |
| 6. | Нийт ажиллагсад | хүн | 959 | 1000 | 956 | 44 | 95.6 |
| 7. | Цалингийн сан | сая.төг | 9,184.4 | 10,704.4 | 10,114.7 | 589.7 | 94.5 |
| 8. | Нийт авлага | сая.төг | 6,260,7 | 3,000.0 | 2,946.4 | 53.6 | 98.2 |
| 9. | Нийт өр төлбөр | сая.төг | 18,519.8 | 12,500.0 | 12,229.7 | 270.3 | 97.8 |
| 10. | Нийт хөрөнгө оруулалт | сая.төг | 1,336.4 | 2,518.8 | 975.8 | 1,543.0 | 38.7 |
| 11. | Ногдол ашиг | сая.төг | 225.6 | 318.6 | 597.2 | (278.6) | 187.4 |
| 12. | Элэгдлийн зардал | сая.төг | 1,011.8 | 1,280.0 | 1,170.2 | 109.8 | 91.4 |